

ТӨСӨЛ

ТАТВАРГҮЙ БАРААНЫ ДЭЛГҮҮР АЖИЛЛУУЛАХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ДУУДЛАГА ХУДАЛДАА ЗОХИОН БАЙГУУЛАХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Татваргүй барааны дэлгүүр ажиллуулах тусгай зөвшөөрөл (цаашид "тусгай зөвшөөрөл" гэх) олгох дуудлага худалдаа зохион байгуулах үйл ажиллагаатай холбогдсон харилцааг энэ журмаар зохицуулна.

1.2.Тусгай зөвшөөрөл олгох дуудлага худалдаа зохион байгуулахтай холбогдсон энэ журмаар зохицуулагдаагүй бусад харилцааг Иргэний хуулийн 197 дугаар зүйл болон Зөвшөөрлийн тухай, мөн Гаалийн тухай хуульд заасны дагуу зохицуулна.

1.3.Тусгай зөвшөөрөл олгох дуудлага худалдааны оролцогчийг сонгон шалгаруулах зарыг нийтлэх, сонгон шалгаруулалтад оролцогчийг бүртгэх, сонгон шалгаруулалтын дүнг нийтэд мэдээлэх, дуудлага худалдааг явуулах, дүнг мэдээлэх, оролцогчийн гомдлыг хүлээн авч шийдвэрлэх зэрэг дуудлага худалдаа зохион байгуулахтай холбоотой бүх үйл ажиллагааг цахим хэлбэрээр, нийтэд ил тод, нээлттэй явуулна.

Хоёр.Дуудлага худалдааг зохион байгуулах ерөнхий нөхцөл

2.1.Гаалийн удирдах төв байгууллага нь дараах тохиолдолд татваргүй барааны дэлгүүр ажиллуулах тусгай зөвшөөрөл олгох дуудлага худалдаа зохион байгуулах шийдвэр гаргаж болно.

2.1.1.хилийн боомтыг шинэчилж, өргөтгөх эсхүл зорчигчийн хөдөлгөөний урсгал нэмэгдсэн;

2.1.2.олон улсын нисэх буудалд татваргүй барааны дэлгүүрийн зориулалтаар үйл ажиллагаа явуулах талбай олгох талаарх нисэх буудлын захиргаанаас тодорхойлолт ирүүлсэн;

2.1.3.дахин дуудлага худалдаа зохион байгуулах;

2.1.4.татваргүй барааны дэлгүүр ажиллуулж байсан аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрөл хүчингүй болсонтой холбоотойгоор татваргүй барааны дэлгүүр ажиллуулах шаардлага үүссэн;

2.1.5.хилийн боомт, олон улсын нисэх буудал шинээр байгуулагдсан

2.1.6.хилийн боомт болон олон улсын нисэх буудалд татваргүй барааны дэлгүүрийн зориулалтаар шинээр зай талбай гаргасан.

2.2.Тусгай зөвшөөрөл олгох дуудлага худалдааг дараах үе шаттай зохион байгуулна:

2.2.1.дуудлага худалдааны оролцогчийн сонгон шалгаруулалт;

2.2.2.хаалттай дуудлага худалдаа.

2.3.Дуудлага худалдаанд оролцогчийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулах тухай зарыг уг сонгон шалгаруулалтад оролцох этгээдийн хүсэлт хүлээн авч эхлэхээс хуанлийн 30-аас доошгүй хоногийн өмнө гаалийн удирдах төв

байгууллагын цахим хуудаст байршуулж, нийтэд зарлана. Сонгон шалгаруулалтын зард хүсэлт хүлээн авч эхлэх болон дуусах хугацаа, хүсэлт ирүүлэх зааварчилгаа, цахим хаяг болон байршлыг тодорхой заасан байна.

2.4. Сонгон шалгаруулалт явуулах, дуудлага худалдаа зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийг гаалийн удирдах төв байгууллагын даргын шийдвэрээр 5-9 хүний бүрэлдэхүүнтэй байгуулна. Тус ажлын хэсгийн дарга нь гаалийн удирдах төв байгууллагын гаалийн хяналт, шалгалтын асуудал хариуцсан нэгжийн дарга байна.

2.5. Ажлын хэсгийн дарга, гишүүн нь дараах эрх, үүрэгтэй байна.

2.5.1. энэ журмын 3.1-т заасан бичиг баримтын бүрдэл дутуу бол тухайн хуулийн этгээдийг сонгон шалгаруулалтад оруулахаас татгалзах;

2.5.2. үндэслэлтэй тохиолдолд тухайн хуулийн этгээдийн бүрдүүлсэн бичиг баримтыг холбогдох байгууллагаар нягтлан шалгуулах, нэмэлт материал гаргуулж авах.

2.5.3. энэ журмын 5.1-д заасан үндэслэлээр дуудлага худалдааг дахин явуулах шийдвэр гаргах;

2.5.4. ажлын хэсгийн гишүүдээс сонгон шалгаруулалтын бичиг баримтыг нээхээс өмнө ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдлийг зохих журмын дагуу авах. Ашиг сонирхлын зөрчил үүссэн байж болзошгүй тохиолдолд сонгон шалгаруулалт болон, дуудлага худалдаанд оролцохоос татгалзах эсэхийг шийдвэрлэх;

2.5.5. сонгон шалгаруулалтад оролцогчийн бизнесийн нууцыг бусдад мэдээлэхгүй, бусдад давуу байдал олгохгүй байх;

2.5.6. сонгон шалгаруулалт болон дуудлага худалдаанд оролцогчийг шударга өрсөлдөх тэгш боломжоор хангах;

2.5.7. дуудлага худалдаа явуулах үеийн программ хангамж, цахим системийн хэвийн ажиллагаа, хөгжүүлэлт, мэдээллийн аюулгүй байдлыг бүрэн хангасан эсэхэд хяналт тавих;

2.5.8. сонгон шалгаруулалт болон дуудлага худалдааны нэгдсэн тайлан, ялагчийн талаарх мэдээллийг ажлын 3 хоногт багтаан цахим системд байршуулж, хуанлийн 7 хоногийн дотор ялагч этгээдтэй гэрээ байгуулна.

2.6. Ажлын хэсэг нь сонгон шалгаруулалтын хүсэлт хүлээн авах хугацаа дууссанаас хойш 1 цагийн дараа сонгон шалгаруулалтыг нээж, ажлын 5 хоногт багтаан шалгаруулалтад тэнцсэн хуулийн этгээдийн жагсаалт гаргаж, тэнцсэн этгээдэд дуудлага худалдаанд оролцох эрх олгох тухай урилга, тэнцээгүй этгээдэд дуудлага худалдаанд оролцуулахаас татгалзсан тухай мэдэгдлийг тус тус цахимаар хүргүүлнэ.

Гурав. Сонгон шалгаруулалт

3.1. Ажлын хэсэг нь сонгон шалгаруулалтын бичиг баримт хүлээн авах хугацаа дууссанаас хойш 1 цагийн дараа нээх бөгөөд ажлын 5 хоногт багтаан Гаалийн тухай хуулийн 139 дүгээр зүйлд заасны дагуу дараах шаардлагыг хангаж байгаа эсэхийг нягтлан шалгана.

3.1.1. тухайн аж ахуйн нэгж нь санхүүгийн чадавхитай болохыг тодорхойлон сүүлийн 3 жилийн санхүүгийн тайлан балансыг баталгаажуулсан аудитын дүгнэлт гаргуулсан байхаас гадна хөрөнгийн хэмжээ нь 1,000,000 ам доллараас доошгүй байгааг баталгаажуулсан банк, татварын байгууллагын

тодорхойлолт, үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ тус бүрийг нотариатоор гэрчлүүлсэн баримт;

3.1.2. татваргүй барааны дэлгүүрт бараа нийлүүлэх туршлагатай, олон улсын тавцанд нэр хүнд бүхий компаниас барааг тогтмол нийлүүлэх гэрээ байгуулсан, түүнчлэн Perfume House-тай Depot agreement хийх талаар баталгаа гаргуулсан байх;

3.1.3. татваргүй барааны дэлгүүрт нийлүүлэгдэх барааны загвар, гэрэл зургийг харуулсан католог, альбом хавсаргасан байх ба барааны хайрцаг, шошго дээр Mongolian duty not paid гэсэн дардастай байх талаар тодорхойлолт гаргасан байх;

3.1.4. татваргүй барааны дэлгүүр ажиллуулах худалдааны танхимын талбайн хэмжээ, тавилга, гэрэлтүүлэг, бараа хадгалах агуулах, туслах өрөөний байрлалыг харуулсан схем, зураглал нь гаалийн хяналтыг зохих журмын дагуу явуулах, гаалийн байцаагчийн өрөөнөөс худалдааны танхим, байр агуулахыг хянах нөхцөлийг бүрдүүлсэн байх;

3.1.5. татваргүй барааны дэлгүүрийг гаалийн нутаг дэвсгэрийн гүнд ажиллуулах тохиолдолд үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ, эсхүл өмчлөгч, эзэмшигчтэй байгуулсан түрээсийн гэрээг нотариатаар гэрчлүүлсэн байх;

3.1.6. тухайн аж ахуйн нэгж, түүний төлөөлөгч, удирдлагууд сүүлийн 3 жилд гаалийн хууль тогтоомж зөрчөөгүй, гаалийн зөрчлийн санд бүртгэгдээгүй байх.

3.2. Дараах нөхцөлийн аль нэг үүссэн тохиолдолд шаардлага хангаагүйд тооцож, оролцогчийг сонгон шалгаруулалтад тэнцээгүй талаарх мэдэгдлийг цахимаар хүргүүлнэ.

3.2.1. энэ журмын 3.1-т заасан шаардлагыг хангаагүй;

3.2.2. Өрсөлдөөний тухай хуулийн 4.1.6-д заасан харилцан хамааралтай этгээдүүд оролцсон тохиолдолд оролцогч этгээд тус бүрийг;

3.2.3. оролцогчийн ирүүлсэн бичиг баримт дутуу, эх хувьтай тулган шалгах шаардлагатай эсхүл дахин ирүүлэхийг ажлын хэсгээс шаардсан хугацаанд ирүүлээгүй.

3.3. Ажлын хэсгийн дарга оролцогчийн ирүүлсэн тодорхойгүй, эсхүл зөрчилдөөнтэй асуудлаар тодруулга авах нь бусад оролцогчийн өрсөлдөөнд сөргөөр нөлөөлөхгүй тохиолдолд хаах хугацаанаас ажлын 2 хоногийн өмнө оролцогчоос бичгээр эсхүл цахимаар тодруулга авах хүсэлт хүргүүлнэ. Энэ хүсэлтэд хариу ирүүлэх хугацааг заасан байна.

3.4. Оролцогчийн ирүүлсэн бичиг баримтын талаар тодруулга авах ажлын хэсгийн даргын хүсэлтэд заасан хугацааны дотор тухайн оролцогч хариу ирүүлээгүй нь шийдвэр гаргах ажиллагааг хойшлуулах үндэслэл болохгүй.

3.5. Ажлын хэсэг нь дуудлага худалдаанд оролцох хуулийн этгээд болон ирүүлсэн бичиг баримт шаардлага хангаж байгаа эсэхэд ажлын 5 хоногийн дотор дүгнэлт гаргана. Сонгон шалгаруулалтад тэнцсэн эсэх жагсаалтыг ажлын 3 хоногийн дотор гаргаж, цахим системд байршуулна.

3.6. Сонгон шалгаруулалтад тэнцсэн оролцогчийг байр эзлүүлэхгүй бөгөөд сонгон шалгаруулалтад оролцохоор бичиг баримт ирүүлсэн хугацааны дарааллаар жагсаалтыг гаргана.

3.7. Оролцогчийг дуудлага худалдаанд оролцуулахаас татгалзсан мэдэгдлийг хүлээн зөвшөөрөхгүй тохиолдолд уг мэдэгдлийг хүргүүлснээс хойш

ажлын 7 хоногийн дотор гаалийн удирдах төв байгууллагын даргад бичгээр гомдол гаргаж болно.

3.8.Гаалийн удирдах төв байгууллагын даргад ирүүлсэн гомдлыг ажлын 7 хоногт шийдвэрлэх бөгөөд шийдвэрийг эс зөвшөөрвөл шүүхэд гомдлоо гаргаж болно.

Дөрөв.Дуудлага худалдаа

4.1.Тусгай зөвшөөрөл олгох дуудлага худалдааг энэ журмын 3.7-д заасан гомдол гаргах хугацаа өнгөрсөн, эсхүл гомдол гаргасан хуулийн этгээдэд хуулийн хугацаанд хариу хүргүүлснээс хойш ажлын 15 хоногийн дотор татваргүй барааны дэлгүүр ажиллуулах зөвшөөрөл олгох цахим системийг ашиглан зохион байгуулна.

4.2.Сонгон шалгаруулалтад тэнцэж, урилга авсан хуулийн этгээд журмын 4.1-т заасан цахим системд бүртгүүлж, дуудлага худалдааны тогтоосон анхны үнийн дүнгийн 10 хувьтай тэнцэх хэмжээний дэнчинг Ажлын хэсгээс мэдэгдсэн дансанд байршуулснаар оролцох эрх үүснэ.

4.3.Дуудлага худалдааны анхны үнэ, өсгөж хэлэх үнийн хязгаарыг доор дурдсаны дагуу зарлан, дуудлага худалдааг эхлүүлнэ.

№	Тусгай зөвшөөрлийн ангилал	Дуудлага худалдааны анхны үнэ (мян.төгрөг)	Өсгөж, хэлэх үнийн хязгаар (мян.төгрөг)
1.	С зэрэглэлтэй буюу хилээр нэвтрэх зорчигчийн тоо багатай боомтод	50.000.0	100.0-1000.0
2.	В зэрэглэлтэй буюу хилээр нэвтрэх зорчигчийн тоо дундаж боомтод	100.000.0	200.0-2000.0
3.	А зэрэглэлтэй буюу хилээр нэвтрэх зорчигчийн тоо ихтэй боомтод	150.000.0	300.0-3000.0

4.4.Үнийн санал өгснөөс хойш хоёр минутын дотор бусад оролцогч өмнөх оролцогчийн өгсөн үнийн саналаас дээш санал өгөөгүй тохиолдолд хамгийн өндөр үнийн санал өгсөн оролцогч этгээд дуудлага худалдааны ялагчаар тодорч, тус тусгай зөвшөөрлийг дуудлагаар худалдсанд тооцож, дуудлага худалдааг хаана.

4.5.Ажлын хэсэг нь дуудлага худалдааны явцад тэмдэглэл үйлдэх бөгөөд уг тэмдэглэлд дуудлага худалдааны ялагч болон Ажлын хэсгийн дарга, гишүүд гарын үсэг зурж, баталгаажуулалт хийснээр дуудлага худалдааг хүчин төгөлдөр зохион байгуулагдсанд тооцно.

4.6.Дуудлага худалдаанд ялсан хуулийн этгээд дуудлага худалдааны үнийг ялагч болсноос хойш 48 цагийн дотор энэ журмын 4.2-т заасан дансанд төлөх үүрэгтэй бөгөөд дэнчинг дуудлага худалдааны үнэд оруулж тооцно.

4.7.Дуудлага худалдаанд оролцогч нь ялагч болоогүй тохиолдолд урьдчилан төлсөн дэнчинг ажлын 2 хоногийн дотор аливаа шимтгэлгүйгээр буцааж олгоно.

4.8.Энэ журмын 4.2-т заасны дагуу дэнчинг байршуулсан боловч дуудлага худалдаанд оролцоогүй хуулийн этгээдийг татгалзсанд тооцож, дуудлага худалдааны тэмдэглэлд тусган, дэнчинг буцааж олгоно.

4.9.Дуудлага худалдааны ялагч нь тэмдэглэл болон гэрээнд гарын үсэг зурахаас зайлсхийсэн тохиолдолд дэнчинг буцаан олгохгүй.

Тав.Дуудлага худалдааг дахин явуулах

5.1.Ажлын хэсэг дараах тохиолдолд дуудлага худалдааг дахин явуулна.

5.1.1.дуудлага худалдаанд нэг этгээд оролцсон;

5.1.2.зөвхөн нэг үнийн санал өгсөн;

5.1.3.дуудлага худалдааны ялагч тогтоосон хугацаанд дуудлага худалдааны үнийг бүрэн төлөөгүй;

5.1.4.дуудлага худалдааны ялагч тэмдэглэлд гарын үсэг зурахаас татгалзсан;

5.1.5.дуудлага худалдааны ялагч энэ журмын 6.1-д заасан хугацаанд гэрээ байгуулаагүй, эсхүл гэрээ байгуулахаас татгалзсан;

5.1.6.хууль зөрчсөн, хууль бус дуудлага худалдаа зохион байгуулагдсаныг шүүхээс тогтоосон;

5.1.7.хуульд заасан бусад тохиолдолд.

5.2.Дуудлага худалдааг дахин явуулах хугацааг Ажлын хэсэг тогтоох бөгөөд энэ тухай зарыг уг журмын 2.7-д заасан урилга авсан этгээдэд дахин дуудлага худалдаа явуулах өдрөөс хуанлийн 15-аас доошгүй хоногийн өмнө хүргэнэ.

Зургаа.Тусгай зөвшөөрөл олгох, гэрээ байгуулах

6.1.Ялагч нь дуудлага худалдааг хүчин төгөлдөр болсноос хойш 6 сарын дотор гэрээний гүйцэтгэлийг хийж, татваргүй барааны дэлгүүрийн горимын шаардлага хангасан баримтыг татваргүй барааны дэлгүүр ажиллуулах цахим системээр илгээнэ.

6.2.Ажлын хэсгийн нэгдсэн тайлан, ялагчийн талаарх мэдээлэл, гэрээний хэрэгжилтийг хангасан, мөн татваргүй барааны дэлгүүрийн горим хэрэгжүүлэх журмын шаардлага хангасан талаар Гаалийн ерөнхий газрын Мэргэжлийн зөвлөлийн хуралдаанд танилцуулж татваргүй барааны дэлгүүр ажиллуулах зөвшөөрөл олгох эсэхийг шийдвэрлүүлнэ.

6.3.Дуудлага худалдааны ялагч гэрээний хэрэгжилтийг 6 сарын дотор биелүүлээгүй тохиолдолд зөвшөөрлийг хүчингүй болгож, дуудлага худалдааг дахин зохион байгуулж болно.

6.4.энэ журмын 6.3-т зааснаар гэрээний хэрэгжилтийг биелүүлээгүй бол дэнчинг буцаан олгохгүй.

Долоо.Бусад

7.1.Гаалийн удирдах төв байгууллага энэ журмын хэрэгжилтэд хяналт тавьж, сонгон шалгаруулалтад оролцохоор ирүүлсэн хүсэлт, холбогдох бичиг баримт, сонгон шалгаруулалтын болон дуудлага худалдааны нэгдсэн тайланг цахимаар ирүүлсэн тохиолдолд цахимаар, цаасаар хэвлэж ирүүлсэн баримтыг архивын нэгж болгон хадгална.

7.2.Сонгон шалгаруулалт, дуудлага худалдаанд оролцогч, Ажлын хэсэг, түүний албан тушаалтан энэ журам болон доор дурдсан хориглосон заалтыг зөрчсөн тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

7.2.1.бусад оролцогчдыг төөрөгдүүлэх, худал мэдээлэл тараах;

7.2.2.дуудлага худалдааны хэвийн үйл ажиллагаанд санаатай саад учруулах;

7.2.3.зохион байгуулагчдын шаардлагыг үл биелүүлэх.

7.3.Дуудлага худалдаанд оролцогч энэ журам болон дуудлага худалдаатай холбоотой аливаа эрх зүйн бичиг баримтыг судлаагүй, тэдгээрийг мэдэхгүй, эсхүл ойлгохгүй байх нь хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

----o0o----